

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн
төвийн 2023 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/05/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
2024 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Баян ташаагийн эх Аудит
ХХК
Захирал: Т.Хоролсүрэн
Утас: 99116028 Цахим хаяг: bte.audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан
3. Санхүүгийн тайлангийн
тодруулга.....
 - 3.1 Компани, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Компанийн гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
.....
- 4.2 Материаллаг байдал
.....
- 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
.....
- 4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
.....
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
.....
- 4.6 Дараагийн аудитаар
анхаарахасуудал.....
5. Аудитын
илрүүлэлт
- ...
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|--------|---|
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.03.15 № 2/90
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн 13/11 тоот тогтоолоор эмнэлгийн барилга 280,850.9 мянган төгрөг, авто зогсоол 3,250.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь 2023 оны үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулаагүй байна. Гүйцэтгэлээр 768,851.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 713,972.9 мянган төгрөгийн зардал гарган, 54,878.9 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

5020337

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---------------|-------------------------------------|------------------------|------------------------|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 286,010.32 | 114,273.37 |
| 1.1.4 | Бусад авлага | 8,150,000.00 | 48,118,407.00 |
| 1.1.6 | Бараа материал | 30,004,205.06 | 25,240,869.10 |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | 38,440,215.38 | 73,473,549.47 |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 392,731,525.00 | 702,938,462.80 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 18,565,000.00 | 18,482,500.00 |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 411,296,525.00 | 721,420,962.80 |
| | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 449,736,740.38 | 794,894,512.27 |
| 2 | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | | |
| 2.2 | Эзэмшигчдийн өмч | | |
| 2.2.1 | Өмч: а) төрийн | 294,561,442.43 | 584,840,269.43 |
| 2.2.2 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 12,690,908.85 | 12,690,908.85 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 73,000,185.40 | 73,000,185.40 |
| 2.4 | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 69,484,203.70 | 124,363,148.59 |
| | Эзэмшигчдийн өмчийн дүн | 449,736,740.38 | 794,894,512.27 |
| | ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | 449,736,740.38 | 794,894,512.27 |

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---------------|---------------------------------------|------------------------|------------------------|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 709,145,439.85 | 768,851,896.32 |
| 3 | Нийт ашиг (алдагдал) | 709,145,439.85 | 768,851,896.32 |
| 7 | Ерөнхий ба удирдлагын зардал | 714,139,345.67 | 713,972,951.43 |
| 12 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | (4,993,905.82) | 54,878,944.89 |
| 14 | Татварын дараах ашиг (алдагдал) | (4,993,905.82) | 54,878,944.89 |
| 18 | Орлогын нийт дүн | (4,993,905.82) | 54,878,944.89 |

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|----------|-----|-------------------------------------|---------------------------|--------------------|----------|
|----------|-----|-------------------------------------|---------------------------|--------------------|----------|

Оточ мандал БГБХ нөхөрлөл Өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|---|-----------------------|----------------------|----------------------|-----------------------|-----------------------|
| 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 291,293,789.14 | 12,690,908.85 | 70,700,185.40 | 74,478,109.52 | 449,162,992.91 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 3,267,653.29 | | 2,300,000.00 | | 5,567,653.29 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | -4,993,905.82 | -4,993,905.82 |
| 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 294,561,442.43 | 12,690,908.85 | 73,000,185.40 | 69,484,203.70 | 449,736,740.38 |
| Өмчид гарсан өөрчлөлт | 290,278,827.00 | | | | 290,278,827.00 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | 54,878,944.89 | 54,878,944.89 |
| 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 584,840,269.43 | 12,690,908.85 | 73,000,185.40 | 124,363,148.59 | 794,894,512.27 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---------------|---|------------------------|------------------------|
| | | 2022 оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 690,563,942.00 | 764,047,573.12 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 203,066,200.00 | 161,821,500.00 |
| 1.1.3 | Татаас, санхүүжилтийн орлого | 461,219,300.00 | 572,384,030.50 |
| 1.1.4 | Бусад мөнгөн орлого | 26,278,442.00 | 29,842,042.62 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн | 595,838,661.40 | 692,143,310.07 |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 300,358,331.00 | 286,979,180.00 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 89,138,527.00 | 91,199,647.00 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 115,567,104.00 | 117,782,769.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 26,339,521.00 | 27,947,611.82 |
| 1.2.5 | Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 6,210,000.00 | 8,142,000.00 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 32,314,924.40 | 31,662,131.80 |
| 1.2.9 | Бусад мөнгөн зарлага | 25,910,254.00 | 128,429,970.45 |
| | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | 166,205.60 | -171,736.95 |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 94,559,075.00 | 72,076,000.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 94,559,075.00 | 72,076,000.00 |
| | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | | |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -165,205.60 | 171,736.95 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 119,804.72 | 286,010.32 |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 286,010.32 | 114,273.37 |

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн зорилт, зорилго үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Аудитын код: БНА-2024/05/НА-СТА-ОНА

- Хүн амд үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж стандартын түвшинд хүргэх.
- Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл сургалт сурталчилгааг сайжруулж иргэдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх
- Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламжийг чанартай үзүүлэх бүх талын бололцоо нөхцөлийг бүрдүүлэх /стандартын шаардлага хангасан
- Өрхийн эмнэлгийнхээ материаллаг баазыг бэхжүүлэх
- Өрхийн эмнэлэгт ажиллагсдыг чадавхжуулах бэлтгэх ,сургаж дадлагажуулах,ур чадвар ёс зүйн түвшинг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах
- Тусламж үйлчилгээний нэр төрлийг олшруулах
- Орон нутаг болон үндэсний хөтөлбөрийг бие хүн, гэр бүл, хамт олны хүрээнд хэрэгжүүлэх.

Тус өрхийн эрүүл мэндийн төв нь Номгон 1-р баг, Рашаант 10-р баг, Угалз 4-р багийн 2,461 өрхийн 10,557 үндсэн хүн ам, 547 өрхийн 1,237 түр оршин суугчдад нийгмийн болон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийг Засгийн газрын 1999 оны 149 тоот тогтоолыг үндэслэн 2001 онд байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 28-ны 08 тоот тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, Аудитын код: БНА-2024/05/НА-СТА-ОНА

нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Нягтлан бодох бүртгэлийн программ байхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар судалж, танилцсан болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 345,157,8 сая төгрөгөөр буюу 76.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|------------------|------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 286.0 | 114.3 | -171.7 |
| Авлага | 8,150.0 | 48,118.4 | 39,968.4 |
| Бараа материал | 30,004.2 | 25,240.9 | -4,763.3 |
| Үндсэн хөрөнгө | 392,731.5 | 702,938.4 | 310,206.9 |
| Биет бус хөрөнгө | 18,565.0 | 18,482.5 | -82.5 |
| Нийт хөрөнгө | 449,736.7 | 794,894.5 | 345,157.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 449,736.7 | 794,894.5 | 345,157.8 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 449,736.7 | 794,894.5 | 345,157.8 |

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 171.7 мянган төгрөгөөр буурсан байна.
- Авлага дансны эхний үлдэгдэл 8,150.0 мянган төгрөгийн авлага барагдаж, тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас авах үйл ажиллагааны санхүүжилтийн авлага 48,118.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

- Бараа материал дансны үлдэгдэл 25,240.9 мянган төгрөг болж 4,763.3 мянган төгрөгөөр буурсан нь бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 714.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 3,471.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, эм, боох материал 8,948.7 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 702,938.4 мянган төгрөг болж 310,206.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр машин тоног төхөөрөмж 47,000.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 25,076.0 мянган төгрөгөөр худалдаж авсан, үнэ төлбөргүй шилжиж ирсэн машин тоног төхөөрөмж 6,187.9 мянган төгрөг, Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 тогтоолоор барилга байгууламж 284,090.9 мянган төгрөг, тайлант хугацааны элэгдлийн зардал 52,147.9 мянган төгрөг гарсантай холбоотой байна.
- Биет бус хөрөнгө 18,482.5 мянган төгрөг болж 82.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 794,894.5 мянган төгрөг болж 345,157.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны ашиг өссөн, үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөө батлуулж ажиллаагүй байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 768,851.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 713,972.9 мянган төгрөгийн зардал гарган, 54,878.9 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар Аудитын код: БНА-2024/05/НА-СТА-ОНА

анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн үйл ажиллагааг сайжруулах холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2024 оны 02 дүгээр сарын 01-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Оточ мадал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 709,145.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,091.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 4,964.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Оточ мандал БГБХ нөхөрлөл өрхийн эрүүл мэндийн төв нь энэ хуулийн хүрээнд өмнөх оноос цалингийн зардал 5,004.5 мянган төгрөг, шатахууны зардал 100.0 төгрөг, бичиг хэргийн зардал 3,893.3 мянган төгрөг, нийт 8,997.8 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд мэдээлэх ёстой орлогын 686,087.1 мянган төгрөгийн мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн 6,285.0 мянган төгрөгийн 3 төлбөрийн төлбөрийн акт зөвлөмж, зөвлөмжийн биелэлтийг үнэлэхэд хэрэгжилт 98.7 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Д.д | Үзүүлэлт | Өмнөх аудитаар өгсөн | | Биелэлт | | |
|-----|-----------------|----------------------|----------------|----------|----------------|-------------|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Төлбөрийн акт | 3 | 6,285.0 | 3 | 6,085.0 | 96.8 |
| 2 | Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100.0 |
| | Нийт дүн | 4 | 6,285.0 | 4 | 6,085.0 | 98.7 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай байна.

Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15–ны өдрийн А/212 тушаалын хавсралт “Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 1.3 “Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна” гэсэн заалтын дагуу байгуулагдсан хуулийн этгээд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэнэ” гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.

Аудитын код: БНА-2024/05/НА-СТА-ОНА

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 42 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх” гэрээний загварт орон нутгийн өмчийг эзэмшүүлэх, ашиглах, түрээслэх заалт нь тодорхой бус, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга, Өрхийн эрүүл мэндийн төвийн даргатай байгуулсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ”-ний 4.1.4 Төвийн ашиглаж буй орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналт, ... 8.1 Төв нь Аймгийн өмчийн газартай “Өмч эзэмших гэрээ” байгуулна, 8.2 Төвд ашиглагдаж буй өмч хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийнэ гэсэн заалтууд нь хоорондоо зөрчилтэй байна.

3. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг 1 иргэнд ноогдох тарифаар тухайн багт харьяалалтай иргэдийн тоогоор төлөвлөдөг боловч зардлыг төлөвлөөгүй байгаа нь зардалд хяналт тавих боломжгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 280,850.9 мянган төгрөгийн алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан. Үүнд:

Үндсэн хөрөнгийн дансанд төлбөргүй шилжиж ирсэн эмнэлгийн барилга үнэ 280,850.9 мянган төгрөг, авто машины зогсоол 3,240.0 мянган төгрөг нийт 284,090.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй байсныг барилга байгууламж дансанд бүртгэсэн.

Аудитаар 2,196.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,196.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Нийт 2,196.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Нэг ажилтанд хавсран ажилласан нэмэгдэл цалин 1,154.6 мянган төгрөг, эмч, сувилагч нарт үр дүнгийн урамшуулал 1,041.8 мянган төгрөг, нийт 2,196.4 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан 2,196.4 мянган төгрөгийг дарга, нягтлан бодогчоор төлүүлж төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2023 оны 9 сард нөхөрлөлийн дарга өөрчлөгдсөн өөрчлөлтийг бүртгүүлээгүй байна. Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ: гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна .

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн этгээдийн өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлийн гэрчилгээнд хийлгэж байх.

5.2.2 Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актаас 200.0 мянган төгрөгийг барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10."аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх"; гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заалтыг дагуу хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|------------------|-----------------------------------|------------------|--------------------------|-----|------------|------------------|---------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруул аагүй | | Тоо | Дүн |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд эмнэлгийн барилга 280,850.9 мянган төгрөг, авто машины зогсоол 3,240.0 мянган төгрөг нийт 284,090.9 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй байсныг барилга байгууламж дансанд бүртгэсэн. | 1 | 280,590.9 | 1 | 280,850.9 | | | 1 | 280,850.9 | | | | |
| Дүн | 1 | 280,590.9 | 1 | 280,850.8 | | | 1 | 280,850.9 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|----------------|---------------|----------------|-----------------------------------|-----|-----------------|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Албан шаардлага | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нэр бүхий ажилтнуудад хавсран ажилласан нэмэгдэл цалин 1,154.6 мянган төгрөг, үр дүнгийн урамшуулал 1,041.8 мянган төгрөг тус тус илүү олгосон байна. | 1 | 2,196.4 | 1 | 2,196.4 | | | | |
| Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актаас 200.0 мянган төгрөгийг барагдуулаагүй байна. | 1 | | | | 1 | | | |
| Дүн | 2 | 2,196.4 | 1 | 2,196.4 | 1 | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|-------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | Тоо | Дүн | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
| Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2023 оны 9 сард нөхөрлөлийн дарга өөрчлөгдсөн өөрчлөлтийг бүртгүүлээгүй байна. | 1 | | 1 | | | |
| Дүн | 1 | | 1 | | | |